

- Ус бохирдуулсны төлбөрийн тухай хууль
- Газрын тухай хууль
- Газрын кадастрын тухай хууль
- Газрын хэвлийн тухай хууль
- Газрын төлбөрийн тухай хууль
- Хог хаягдлын тухай хууль
- Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай хууль
- Ургамал хамгааллын тухай хууль
- Ан амьтны тухай хууль
- Усны тухай хууль
- Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хууль
- Хог хаягдлын улсын тоо бүртгэл хөтлөх, тайлагнах журам, 2018 он
- Ахуйн бохир ус хаях цооногийг доторлож ашиглах журам, 1995 он
- Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хууль
- Химийн хорт болон аюултай бодис экспортлох, импортлох, хил дамжуулан тээвэрлэх болон үйлдвэрлэх, худалдах журам, 2009 он
- Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээнд олон нийтийн оролцоог хангах тухай журам, 2014 он
- Ус ашиглалт, хэрэглээг тоолууржуулах журам, 2013 он
- Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам, 2019 он
- Усны сан бүхий газрын онцгой болон энгийн хамгаалалтын бүс, ус хангамжийн эх үүсвэрийн эрүүл ахуйн бүсийн дэглэм, 2009 он
- MNS 4585:2016 Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага
- MNS 5919:2008 Дулааны цахилгаан станц, дулааны станцын уурын ба ус халаах зуухны ашиглалтын үед агаар мандалд хаях утааны найрлага дахь агаар бохирдуулах зарим бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ, тэдгээрийг хэмжих арга
- MNS 0900:2018 Хүрээлэн буй орчин. Эрүүл мэндийг хамгаалах. Аюулгүй байдал. Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ
- MNS 4943:2015 Хүрээлэн байгаа орчин. Усны чанар. Хаягдал ус. Ерөнхий шаардлага
- MNS 6148:2010 Усны чанар. Газрын доорхи усыг бохирдуулагч бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ
- MNS 5850:2019 Хөрсний чанар. Хөрсөнд агуулагдах бохирдуулах бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ
- MNS 6515:2015 Тал хээр, говь цөлийн бүсийн авто болон төмөр зам дагуу зэрлэг амьтдад зориулсан гарц. Ерөнхий шаардлага
- MNS 7042:2024 Төмөр зам болон хурдны авто замын хориг хашаа. Ерөнхий шаардлага

2. МОНГОЛЫН ТӨМӨР ЗАМ ТӨХК-ИЙН ТУХАЙ ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Монгол Улсын Их Хурлаас 2010 оны 6 дугаар сарын 24-ний өдрийн 32 тоот тогтоолоор “Төрөөс төмөр замын тээврийн талаар баримтлах бодлого”-г баталж, “Төмөр замын тээврийн талаар төрөөс баримтлах бодлого (Төмөр замын бодлого)”-ын дагуу бусад улс орнууд руу уул уурхайн бүтээгдэхүүнийг экспортлох, томоохон уул уурхайн газруудыг холбосон төмөр замын сүлжээг сайжруулах зорилгоор 3 үе шаттайгаар 5600 орчим км төмөр замын дэд бүтцийг барьж байгуулна гэж заасан. “Төмөр замын тээврийн талаар төрөөс баримтлах” бодлогын хэрэгжилтийг хангах зорилгоор 2019 оны 06 дугаар сарын 12-ны өдрийн ЗГ-ын 232 дугаар тогтоолоор Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын трасс шугамыг баталсан байна.


Төслийн захиалагчаар “Монголын төмөр зам” ТӨХК, гүйцэтгэгчээр Зэвсэгт хүчний Жанжин штаын Зэвсэгт хүчний бүтээн байгуулалтын дэмжлэгийн газар, дэд бүтцийн ерөнхий гүйцэтгэгчээр “Улаанбаатар төмөр зам” хувь нийлүүлсэн нийгэмлэг тус тус ажилласан.

Замын барилгын ажилд захиалагчийн хяналтын чиг үүргийг “Тавантолгой төмөр зам” ХХК-иар гүйцэтгүүлэхээр Зам, тээврийн хөгжлийн сайдын зөвлөлийн 2019 оны 14 дүгээр хуралдаанаас шийдвэрлэсний дагуу “Монголын төмөр зам” ТӨХК болон “Тавантолгой төмөр зам” ХХК-ийн хооронд “Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын төслийн барилгын ажилд захиалагчийн хяналтыг хэрэгжүүлэх тухай гэрээ”-г байгуулж, “Тавантолгой төмөр зам” ХХК нь төслийн барилгын ажил батлагдсан зураг, төсөл, норм, норматив, техникийн баримт бичгийн дагуу хийж байгаа эсэх, байгаль орчин, хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн төлөвлөгөөний дагуу явагдаж байгаа эсэхэд хяналт тавих, зөвлөгөө өгөх чиг үүрэгтэй ажилласан.

Монголын өмнөд хэсгийн төмөр замын шугам болох Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын трасс нь Өмнөговь аймгийн Цогтцэций сумын нутагт байрлах Тавантолгойн бүлэг ордоос зүүн тийш Дорноговь аймгийн Сайншанд сумын Зүүнбаян өртөө чиглэд нийт 416.16 км үргэлжилсэн.

2023 оны тавдугаар сард Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замыг байнгын ашиглалтад хүлээн авсан. Тус төмөр зам нь жилд 15-20 сая тн ачаа

тээх хүчин чадалтай, гол замын даац 25 тн, нэг өртөө, зургаан зөрлөг бүхий гуравдугаар зэрэглэлийн төмөр зам юм.



Зураг 1. Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр зам

3. АУДИТЫН ДҮН

Аудитын хүрээнд байгаль орчны холбогдох хууль тогтоомж, дүрэм, журам, стандарт, байгаль орчны нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээ (БОНБНУ), байгаль орчны менежментийн төлөвлөгөө (БОМТ), орчны хяналт шинжилгээний хөтөлбөр (ОХШХ)-ийн хэрэгжилтийг авч үзлээ.

Нийт 65 шалгуур үзүүлэлтээр байгаль орчны хууль, дүрэм, журам, стандарт болон бусад шаардлагууд хэр сайн биелсэнийг шалгаж үзэхэд 48 шалгуур бүрэн биелсэн, 6 шалгуур бүрэн бус, 11 шалгуур биелээгүй гэсэн дүн гарч байна. Өөрөөр хэлбэл “Монголын төмөр зам” ТӨХК нь хууль тогтоомж, дүрэм, журмын хүрээнд хүлээх үүргээ 73,8%-тай биелүүлж байна (График 1). Аудитын үнэлгээгээр биелээгүй болон бүрэн бус биелсэн шалгуурууд буюу үл тохиролд эрсдэлийн үнэлгээ хийж үзэхэд 4 дунд, 13 бага эрсдэлтэй гарсан (Хүснэгт 1).




График 1. Байгаль орчны аудитын нэгдсэн дүн

Хүснэгт 1. Эрсдэлийн үнэлгээ

Д-д	Байгаль орчны бүрдэл хэсэг	Шалгуур	Үл тохирол	Үнэлэмж	Эрсдэлийн үнэлгээ		
					Хүний эрүүл мэнд байгаль орчны нөлөөллийн түвшин	Хүний эрүүл мэнд байгаль орчинд хохирол учруулах магадлал	Эрсдэлийн зэрэг
1	Ерөнхий шалгуур	БОАЖЯС-ын 2019 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн А/618 тоот тушаалын хавсралт БОМТөлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам	2019-2023 онд БОМТ батлуулсан, 2020 оны БОМТ-ний биелэлттэй, 2023 оноос хойш БОМТ боловсруулаагүй	Биелээгүй	Бага	Бага	1
2	Ерөнхий шалгуур	"Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам"-ын 2.3-р зүйлд "Төсөл хэрэгжүүлэгч байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх ажлын зардлыг бүрэн тооцож түүний 50 хувийн барьцааг хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигч сумын байгаль орчны барьцаа хөрөнгийн, ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч байгаль орчны төрийн захиргааны төв байгууллагын байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх тусгай баталгааны тусгай дансанд тус тус байршуулна	Төсөл хэрэгжүүлэгч байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх ажлын зардлыг бүрэн тооцож түүний 50 хувийн барьцааг байгаль орчны төрийн захиргааны төв байгууллагын байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх тусгай баталгааны тусгай дансанд байршуулаагүй	Биелээгүй	бага	бага	1

3	Ерөнхий шалгуур	Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 8.3. Энэ хуулийн 8.2-т заасан эрх бүхий аж ахуйн нэгж нь байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний үр дүнгээр тайлан бэлтгэж, байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулна.	2019-2023 оны БОННУ-г боловсруулсан. Тавантолгой-Зүүнбаян төмөр замын төслийн 2025 онд БОННУ-ний тендер шалгаруулалт хийгдсэн.	Бүрэн бус	бага	бага	1
4	Ерөнхий шалгуур	БОНБУТХ 9.7. Орчны хяналт-шинжилгээний хөтөлбөрт төслийн үйл ажиллагааны улмаас байгаль орчны төлөв байдалд үзүүлж байгаа өөрчлөлтийг хянах, шинжилгээ хийх, үр дүнг тайлагнах, түүнийг хэрэгжүүлэх арга хэлбэр, шаардагдах хөрөнгө, зардал, хугацааг тодорхойлон тусгана.	2019-2023 Орчны хяналт-шинжилгээний хөтөлбөрт төслийн үйл ажиллагааны улмаас байгаль орчны төлөв байдалд үзүүлж байгаа өөрчлөлтийг хянах, шинжилгээ хийх, үр дүнг тайлагнах, түүнийг хэрэгжүүлэх арга хэлбэр, шаардагдах хөрөнгө, зардал, хугацааг тодорхойлон тусгасан. 2024-2025 онд ОХШХ байхгүй.	Бүрэн бус	бага	бага	1
5	Ерөнхий шалгуур	Байгалийн баялгийг үйлдвэрлэлийн зориулалтаар ашиглахыг хүсч байгаа иргэн, аж ахуйн нэгж, байгууллага энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан үнэлгээг өөрийн зардлаар хийлгэх буюу үнэлгээг урьд нь тогтоосон бол түүнийг гүйцэтгэсний зардлыг төлнө	2019 онд “Тавантолгой-Зүүнбаян” чиглэлийн 414.6 км төмөр замын төслийн байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээг “Өндөрхаан трейд” ХХК-иар хийлгэсэн байна. 2025 онд БОННУ-ний тендер шалгаруулалт хийгдсэн.	Бүрэн бус	Бага	Бага	1
6	Агаар	АтХ 9.1. агаар хамгаалахтай холбогдсон дүрэм, журам, бохирдуулах бодисын хаягдлын	2023-2025 онд агаарын чанарын хяналт хийгдээгүй.	Биелээгүй	Бага	Бага	1